



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ
(Захиргааны эрх зүйн маргаан)

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ СОГТУУ ЭСЭХЭЭ ШАЛГУУЛАХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ХУУЛИЙН ШААРДЛАГЫГ
БИЕЛҮҮЛЭХГҮЙ БАЙЖ БОЛОХГҮЙ**

2021 оны дөрөвдүгээр сарын нэгэн шөнө Евгений Перепелицын* Chevrolet Lacetti маркийн автомашины жолоодлого алдаж жалга руу унаж осолджээ. Маргааш өглөө нь осолдсон машиныг Липецк мужийн Грязинск дүүргийн цагдаагийн газрын жижүүр олжээ. Тус газар замын цагдаа тээврийн хэрэгслийн ослын тэмдэглэл үйлдэх гэж байгаад автомашины эзнийг осол гарсан газраас олжээ. Тэр амьд байв.

Жолоодох эрхийг түдгэлзүүлэх тухай тэмдэглэлд: автомашины эзнийг олсон үед амнаас нь архи үнэртэж, ганхаж, ойлгомжгүй ярьсан гэж дурдсан бөгөөд автомашины эзэн Перепелицын замын цагдаад согтуу мэт сэтгэгдэл төрүүлсэн байна. Замын цагдаа автомашины эзнийг согтуу эсэхээ шалгуулж эмнэлгийн үзлэгт орохыг шаардсан боловч Перепелицын татгалзсан. Тэрээр архи уусан гэдгээ үгүйсгээгүй, харин ослын дараа л уусан гэжээ.

Перепелицыны эдгээр үгэнд нь Грязинск шүүхийн тойргийн энх тайвны шүүгч итгээгүй бөгөөд шүүгч ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.26 дугаар (*“Тээврийн хэрэгслийн жолооч согтуу эсэхээ шалгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдах шаардлагыг биелүүлээгүй”*)¹ зүйлд заасны дагуу зөрчил гаргагч Перепелицыны хагас жилийн хугацаанд машин жолоодох эрхийг нь хасаж, түүнд 30 000 рублийн хэмжээтэй торгууль ногдуулжээ.

Перепелицын энэ шийдвэрийг Липецк мужийн Грязинск хотын шүүхэд давж заалджээ. Тус шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Учир нь тус шүүхийн үзэж байгаагаар, ослын улмаас зөвхөн осолд буруутай этгээдийн эд хөрөнгө хохирсон, тэрээр осол болсон газрыг орхиж явж, өөрийгөө замын цагдаад мэдэгдэхгүй байж болох байсан. Түүнд ослын дараа согтууруулах ундаа

¹ Кодекс Российской Федерации об административных правонарушениях" от 30.12.2001 N 195-ФЗ// (ОХУ-ын 2001 оны 12 сарын 30-ны өдрийн N 195 “Захиргааны зөрчлийн тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/ [Сүүлд үзсэн: 2023.04.03]



хэрэглэхийг хэн ч хориглоогүй хэмээн Грязинск хотын шүүхийн шийдвэрт дурдсан байна. Мөн цагдаа нарт эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг шаардах хууль зүйн үндэслэл байгаагүй гэжээ.

Энэхүү шийдвэрийг ОХУ-ын Липецк мужийн Грязинск дүүргийн Цагдаагийн газрын дарга Сергей Финогин эсэргүүцэв. Ерөнхий Харьяаллын Нэгдүгээр Хяналтын Шатны шүүхийн орлогч дарга Инна Переверзева түүнтэй санал нэг байгаагаа илэрхийлэв. Түүний бодлоор 2022 оны 3-р сарын 11-ний өдрийн 16-1406 / 2022 тоот тогтоолд дурдсанаар машин зогссон эсвэл осол болж өнгөрсөн үеэс үл хамааран замын цагдаагийн ажилтан согтуу хүний гадаад байдлын шинж тэмдгийг олж харсан даруйдаа зөрчил гаргагчийн согтуу байсан эсэхийг тогтоох үүрэгтэй.

Хотын шүүхийн шийдвэрээс үл хамааран автомашины жолооч ослын дараа архи уух ёсгүй байсан гэж шүүгч Переверзева үзсэн байна. Доод шатны буюу Липецк мужийн Грязинск хотын шүүх ОХУ-ын Улсын Дээд Шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолын 20 дугаар хэсгийн 10 дахь заалтыг анхааралдаа аваагүй. Тус тогтоолд “эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.26 дахь зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэл оногдуулна” гэж заасан байна. Дээрх агуулгаар Ерөнхий Харьяаллын Нэгдүгээр Хяналтын Шатны шүүх Грязинск хотын шүүхэд хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.²

Анхааруулга: ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 “Хувийн мэдээллийн тухай” хуулийн 7 дугаар зүйлд “Хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй операторууд болон бусад этгээдүүд ОХУ-ын хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр түүний хувийн мэдээллийг гуравдагч этгээдүүдэд задруулахгүй, бусдад тараахгүй байх үүрэгтэй”³ гэж зааснаар тус шийдвэрийг орчуулахдаа хүний нэрийг өөрчилж бичсэн болно.

² Постановление первого кассационного суда общей юрисдикции от 11 марта 2022 года № 16-1406/2022/(Ерөнхий харьяаллын нэгдүгээр хяналтын шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн № 16-1406/2022 тогтоол) URL: http://1kas.sudrf.ru/modules.php?name=sud_delo&srv_num=1&name_op=doc&number=17230191&delo_id=2550001&new=0&text_number=1 [Сүүлд үзсэн: 2023.04.03]

³ ст. 7 Федерального закона "О персональных данных" от 27.07.2006 N 152-ФЗ (последняя редакция)// (ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 "Хувийн мэдээллийн тухай" хуулийн 7 дугаар



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

Орчуулсан: С. Жансая

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн

Үндсэн хууль, олон улсын эрх зүйн судлаач